

**6-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ  
ДЭВШИХ ШАЛГАЛТ -2024**

**Хувилбар “А”**

**Нийт 20 оноо**

- Шалгалт 60 минут үргэлжилнэ.
- Даалгавар бүрийн хариултыг өгөгдсөн зайд бичиж тэмдэглэнэ.

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.**

Эхийг уншиж, даалгаврыг гүйцэтгээрэй.

**Ээжийн царай**

Нэгэн тосгонд нүүр болон гар нь татанги болсон эх амьдардаг байжээ.

Сэтгэл нь гадаад төрхтэй нь харьцуулбал илүү сайхан байсан ч тосгоныхноосоо үргэлж нуугддаг байв.

Тэр эхийн ганц хүү нь үеийнхнээсээ илүү ухаалаг хөдөлгөөнтэй зоригтой аж. Харин найзуудтайгаа тоглож байхад нь хажуугаар нь ээж нь өнгөрвөл ичих сэтгэл төрдөг байлаа. **Нэгэн өдөр түүнийг хүлээн зогссон ээжийг нь найзууд нь шоолжээ.** Бухимдаж бачимдсан хүү гэртээ ирмэгцээ ээж рүүгээ хашгичиж ээжийнхээ муухай нүүрнээс ичиж байдаг тул дахин сургууль дээр битгий очоорой гэж хэлэв.

Үүнийг сонсож байсан хөршийнх нь эмээ тэсэлгүй хүүг дуудаж: “Чамайг нэг настай байх үе юмсан. Ээж чинь талбайд ажиллаж байтал гэрт чинь гал гарч, дотор нь чи унтаж байсан. Галын дөл хүчтэй байснаас тосгоныхны хэн нь ч орж зүрхлээгүй байтал нэгэн жижигхэн эмэгтэй хүмүүсийн дундаас зүсэн гарч ирээд гал руу орчихсон нь ээж чинь байсан юмдаа. Улалзан асах галын дундаас чамайг тэврэн гарч ирэхэд түүний нүүр гар түлэгдсэн байлаа” гэж хэлжээ.

Үүнийг сонсоод хүү нулимс асгаруулан өөрийн эрхгүй гэмшин, ээжээрээ бахархах сэтгэл төржээ.

1. Эхийн дүр төрх ямар байсныг эхээс олж бичээрэй. /2 оноо/

.....

.....

.....

2. Хүү нулимс асгаруулан өөрийн эрхгүй гэмшин, ээжээрээ бахархах сэтгэл төрсөн шалтгаан юу вэ? /2оноо\

.....

.....

.....

3. Дээрх эхээс жинхэнэ нэр 4-ийг олж бичээрэй /2 оноо/

.....

.....

.....

4. “Царай” гэдэг үгийг тийн ялгалаар хувилгаарай /4 оноо\

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....


5. “Шидэт бийр” үлгэрийг уншаад чамд ямар сэтгэгдэл төрсөн бэ? Хэрэв чамд шидэт бийр олдвол юу хийх вэ? дэлгэрүүлэн бичээрэй./3 оноо/

.....  
.....  
.....

6. Дараах зохиолуудыг зохиолчтой нь зөв харгалзуулаарай. \2 оноо\

- |                   |                  |
|-------------------|------------------|
| 1. Шаргачин       | А. Ч. Лодойдамба |
| 2. Алт мөнгө хоёр | Б.               |
| 3. Зүрх цагаан    | В.               |

7. Үндэсний бичгээр бичсэн зүйр цэцэн үгийг цэвэрхэн хуулж бичээд, кириллээр хөрвүүлээрэй.\5 оноо\



**6-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ  
ДЭВШИХ ШАЛГАЛТ**

**Хувилбар “Б”**

**Нийт: 20 оноо**

- Шалгалт 60 минут үргэлжилнэ.
- Даалгавар бүрийн хариултыг өгөгдсөн зайд бичиж тэмдэглэнэ.

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.**

**“Багваахай цэцэг”**

Багваахай цэцэг ихэд бардам зантай тул бусад цэцэг түүнтэй үерхэж нөхөрлөхийг хүсдэггүй ажээ. Нэгэн үдэш гэрэлт цох хорхой, огторгуйд хурц од гялалзан явахыг үзээд,

-Энэ чинь хиймэл дагуул байна. Би хол нисдэг бол үүнтэй адил гэрэлтэх байсан даа хэмээн хэлээд санаа алдав. Тэгэхэд багваахай цэцэг:

- Чи ч яамай байна аа. Харин би хиймэл дагуул болж чадна. Надад сар шиг дугариг, эвхэж, хумхиж, бас дэлгэж нээгддэг шүхэр бий. Та нар харж байгаарай. Би тэнгэрийн мандал өөд одоо нислээ! гэжээ. Энэхүү бардам зантын үгийг сонсоод бүх цэцэг гайхан шуугилдав.

Гэтэл гэнэт бөөн хар үүл гарч ирж их салхин исгэрэв. Бүгд чимээгүй болж их салхи, ширүүн бороог өнгөрүүлэхээр сандрав. Багваахай цэцэг ихэд хичээн, дэрсэн хөл дээрээ тогтож ядан дэнжигнэж байлаа. Хэдэн мөчийн дараа багваахай цэцэг байрандаа байсангүй, зөвхөн иш нь үлджээ. Бутны цаанаас туулай босоод үлдсэн ишийг нь идэж орхив.

-Чи яагаад түүнийг идчихэв? Наадах чинь нүцгэн ишээрээ их бардам зогсож байсан шүү! гэж дэргэдэх цэцгүүд нь хэлэхэд,

- Өө тийм үү? Анзаарсангүй хэмээн туулай хариулж гэнэ.

1.Эхийн гол санааг бичээрэй. \2 оноо\

.....

2.Эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ? \2 оноо\

.....

3. Дээрх эхээс жинхэнэ нэр 4-ийг олж бичнэ үү.\2 оноо\

.....

4.“Багваахай” -гэдэг үгийг 8 тийн ялгалаар хувилгаарай \4 оноо\

.....

.....

.....

.....

.....

.....

5.Эхээс багваахай цэцгийг бардам зантай болохыг нотолсон хэсгийг олж бич. /3 оноо\

.....  
.....  
.....  
.....

6. Дараах зохиолуудыг зохиолчтой нь зөв харгалзуулаарай. \2 оноо\

- |                   |                  |
|-------------------|------------------|
| 1. Шаргачин       | А. Ч. Лодойдамба |
| 2. Алт мөнгө хоёр | Б. Д. Давааням   |
| 3. Зүрх цагаан    | В. П. Хорлоо     |

7.Дараах зүйр үгсийг хуулж бичээд, кирилл бичигт хөрвүүлээрэй.\5 оноо\

ᠰᠢᠷᠭᠠᠴᠢᠨ      ᠠᠴᠢᠯᠠᠮᠤᠨᠠᠮ  
ᠠᠯᠲᠤᠮᠥᠩᠭᠡᠬᠡᠶᠢᠷ      ᠬᠣᠷᠯᠤᠭᠤ  
ᠵᠢᠷᠦᠬᠡᠴᠠᠭᠠᠨ      ᠰᠢᠷᠭᠠᠴᠢᠨ

“Түлхүүр”

Хувилбар Б

Д\Д	Асуулт	Нэмэлт тайлбар	Авах оноо
1	Эхийн гол санаа	“ Өөрийн хэр хэмжээг мэдэхгүй бардам зан гаргавал хол явдаггүй ” гэсэн санааг Бүрэн гаргавал 2 оноо Дөхүүлсэн бол 1.5 Дутуу бичсэн бол 1 оноо Буруу болон бичээгүй бол 0 оноо	2 оноо
2	Эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?	Бардам зантай багваахай цэцгийн тухай	2 оноо
3	Дээрх эхээс жинхэнэ нэр 4-ийг олж бичнэ үү	4-өөс дээш үг олсон бол 2 оноо 3 үг олсон бол 1.5 оноо 2 үг олсон бол 1 оноо 1 үг олсон бол 0.5 Зөв үг олоогүй бол 0 оноо	2 оноо
4	Багваахай- гэдэг үгийг тийн ялгалаар хувилгаарай	Бүтэн хийсэн бол 4 оноо 2 дутуу байвал 3 оноо 3 дутуу бол 2оноо 4 болон түүнээс дээш алдсан бол 0 оноо	4 оноо
5	Багваахай цэцгийг бардам зантай болохыг нотолсон хэсгийг олж бичих	-Чи ч яамай байна аа.Харин би хиймэл дагуул болж чадна.Надад сар шиг дугариг, эвхэж, хумхиж, бас дэлгэж нээгддэг шүхэр бий.Та нар харж байгаарай. Би тэнгэрийн мандал өөд одоо нислээ!гэжээ. Бүрэн олсон бол 3 оноо Дутуу бол 2 оноо Олоогүй бол 1 оноо	3 оноо
6	Зохиолуудыг зохиолчтой нь зөв харгалзуулах	1. А 2. В 3. Б 3-ыг зөв харгалзуулсан бол 2 оноо 2-ыг зөв харгалзуулсан бол 1.5 оноо 1-ыг зөв харгалзуулсан бол 1 оноо Огт олоогүй бол 0 оноо	2 оноо
7	Үндэсний бичиг	Дамын үг далан худалтай Зуурын үг зуун худалтай Бичгийн хэв 1 оноо ,үг тус бүр 0.5	5 оноо
		<b>Нийт 20 оноо</b>	

### Хувилбар А

Д\д	Асуулт	Нэмэлт тайлбар	Авах оноо
1	Эхийн дүр төрх ямар байсныг олж бичээрэй.	Эхийнх нь нүүр болон гар нь татанги болсон, сэтгэл нь гадаад төрхтэй нь харьцуулбал илүү сайхан байсан.  Бүрэн гаргавал 2 оноо Дөхүүлсэн бол 1.5 Дутуу бичсэн бол 1 оноо Буруу болон бичээгүй бол 0 оноо	2 оноо
2	Хүү нулимс асгаруулан өөрийн эрхгүй гэшин, ээжээрээ бахархах сэтгэл төрсөн шалтгаан юу вэ?	Ээж нь талбайд ажиллаж байхад гэрт гал гарч, хүү гэртээ унштаж байсныг аврахаар гал руу зүсэн орж хүүгээ тэврэн гарч ирэхэд нүүр гар нь түлэгдэж ийм царайтай болсныг хажуу айлын эмээгээс сонссон.	2 оноо
3	Дээрх эхээс жинхэнэ нэр 4-ийг олж бичнэ үү	4-өөс дээш үг олсон бол 2 оноо 3 үг олсон бол 1.5 оноо 2 үг олсон бол 1 оноо 1 үг олсон бол 0.5 Зөв үг олоогүй бол 0 оноо	2 оноо
4	Царай- гэдэг үгийг тийн ялгалаар хувилгаарай	Бүтэн хийсэн бол 4 оноо 2 дутуу байвал 3 оноо 3 дутуу бол 2 4 болон түүнээс дээш алдсан бол 0 оноо	4 оноо
5	“Шидэт бийр” үлгэрийг уншаад чамд ямар сэтгэгдэл төрсөн бэ? Хэрэв чамд шидэт бийр олдвол юу хийх вэ? дэлгэрүүлэн бичээрэй.	Сэтгэгдлээ илэрхийлэн бичээд өөрийн санаагаа 2-3 өгүүлбэрээр илэрхийлсэн бол 3 оноо Аль нэг нь дутуу бол 2.5 Үгээр илэрхийлсэн бол 2 оноог тус тус өгнө.	3 оноо
6	Зохиолуудыг зохиолчтой нь зөв харгалзуулах	4. А 5. В 6. Б  3-ыг зөв харгалзуулсан бол 2 оноо 2-ыг зөв харгалзуулсан бол 1.5 оноо 1-ыг зөв харгалзуулсан бол 1 оноо Огт олоогүй бол 0 оноо	2 оноо
7	Үндэсний бичиг	Явсан нохой яс зууна. Хэлсэнд нь итгэхээр хийсэнд нь итгэ. Бичгийн хэв 1 оноо хөрвүүлэг 4 оноо	5 оноо
		<b>Нийт 20 оноо</b>	